



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/586

Булган сум

**Батламж хэвлүүлэх зардал
гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II дугаар хуралдааны II/04 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангиа амжилттай төгсөж, элсэлтийн ерөнхий шалгалт, урлаг, спортын амжилтаараа манлайлан аймгийн Засаг даргын тэтгэлэгт хамрагдсан сурагчдад батламжийг гардуулсугай.

2. Батламжийг хэвлүүлэхэд шаардагдах 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжаар батлагдсан “Шинэ Ирээдүй” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

0324010803

Аймгийн Засаг даргын 2024 оны 08
дугаар сарын 15-ны өдрийн дугаар
захирамжийн хавсралт

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТЭТГЭЛЭГТ ХАМРАГДСАН СУРАГЧДАД ГАРДУУЛАХ БАТЛАМЖ
ХЭВЛҮҮЛЭХ ТӨСӨВ

№	ЗАРДЛЫН ТӨРӨЛ	ХЭМЖИХ НЭГЖ	ТОО ХЭМЖЭЭ	НЭГЖ ҮНЭ	НИЙТ
1	БНСУ-ын Шинхан их сургуульд суралцах сурагчдын батламж	Ширхэг	50	4000	200,000
2	Монгол улсын их, дээд сургуульд суралцах сурагчдын батламж	Ширхэг	50	4000	200,000
Нийт					400,000